

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 10 дугаар сарын 13-ны өдөр

Дугаар 317

Улаанбаатар хот

ТОГТООЛЫН ХАВСРАЛТАД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13.1.9, 13.2, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 38.1.6, 38.2-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Засгийн газрын 2015 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 503 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Хийн түлш, хийн түлшний сав, тоног төхөөрөмж, тусгай зориулалтын машин, техник хэрэгсэл, тоноглолын жагсаалт"-д дор дурдсан дэд заалт тус тус нэмсүгэй:

№	Код	Барааны нэр, төрөл
А.Хийн түлш		
5 ¹	27 11. 19. 00	Шингэрүүлсэн бусад хий: пропан, метан, этан, бутаны холимог
Б.Хийн түлшний хангамж, хэрэглээний сав, тоног төхөөрөмж, тусгай зориулалтын машин, техник хэрэгсэл, тоноглол		
10 ¹	72 10. 12. 00	Төмөр эсвэл чанаржуулаагүй гангаар хийсэн хавтгайлж цувисан бүтээгдэхүүн (Хийн баллоны их биеийг хийхэд зориулагдсан)
10 ²	72 10. 70. 00	Будсан, лакдсан, хуванцар давхарга суулгасан төмөр эсвэл чанаржуулаагүй гангаар хийсэн хавтгайлж цувисан бүтээгдэхүүн (Хийн баллоны их биеийг хийхэд зориулагдсан)
17 ¹	73 18. 19. 00	Төмөр эсвэл гангаар хийсэн пүрштэй даравч (Хийн баллонд зориулагдсан)
27 ¹	84. 02	Хийн түлшээр ажилладаг уурын тогоо эсвэл өндөр даралтын уурын бусад тогоо (бойлер)
27 ²	84 02. 90. 00	Дулааны болон үйлдвэрлэлийн халаалт, технологийн зориулалттай хийн түлшээр ажилладаг уур гаргадаг бойлерын эд анги: (Их бие, суурь, тогоон дотор угсрагддаг хоолой, усны хоолойд угсрагддаг хошуу, ус хуримтлуулагч, уурын барабан, хатаагч, механик биш галлагч, хяналтын таг, галын крант)
28 ¹	84 03. 90. 00	Хийн түлшээр ажилладаг төвлөрсөн халаалтын халуун усны тогооны эд анги: (Тогооны бүрхүүл, хана, хаалга, хүхээ, шалгах хэсгийн таг)
28 ²	83 09. 90. 00	Металлан бөглөө, таглаа, таг (Хийн баллонд зориулагдсан)
63 ¹	84 62. 29. 00	Хийн баллоны ирмэг гаргагч, эмхэрдэгч төхөөрөмж